



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 8/03

Шивээговь сум

Т.Өлзийбудыг Байгаль орчны асуудал  
хариуцсан мэргэжилтнээр түр  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт зарлагдаж, сул орон тоо нөхөгдөх хүртэл хугацаанд Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнээр Төмөрбаатарын Өлзийбудыг 2022 оны 01 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Т.Өлзийбудад ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

Гишүүд:

Ц.Замбага

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Д.Гантогтох

(Нярав)

3. Т.Өлзийбудын сарын үндсэн цалинг 585,493 (таван зуун наян таван мянга дөрвөн зуун ерэн гурав) төгрөгөөр бодож сар бүр олгохыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Ажлыг чанартай зохион байгуулж, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (О.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.ОТГОНЖАРГАЛ

D:\2022 oni barimt\TDarga\tushaal

422220010